

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2023 оны 09 дугаар сарын 13-ны
өдрийн 44 дугаар тушаалын 62 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр
огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нийслэлийн Засаг даргын
хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн
нийтлэг үйлчилгээний газар

Нэгжийн нэр:

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Эрүүл ахуйч эмч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гүйцэтгэх албан тушаалтан ТҮ-6

Ажлын цаг

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хангарди ордон, Ц.Жигжиджавын
гудамж - 9, 1 дүгээр хороо, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Шаардлагатай үед амралт, баяр
ёслолын өдрүүдэд ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл ахуй, халдвар судлалын болон хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормативийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, салбарын хяналтын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж ажиллах.


Албан тушаалын зорилт:

1. Зоогийн газрын хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх
2. Хариуцсан хяналтын ажлын чиглэлээр эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зоогийн газруудад зохион байгуулах
3. Хариуцсан ажлын хүрээнд зоогийн газруудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
4. Мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх, ажлын байранд сурч хөгжих, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах
5. Холбогдох хууль дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах
6. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журмыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Зоогийн газрын хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд хийх хяналтын бодлогыг хэрэгжүүлэх.</p> <p>1.2. Эрүүл ахуйн хяналт шалгалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг тайлагнах, арга хэмжээ авч ажиллах</p> <p>1.3. Эрүүл ахуйн чиглэлээр зоогийн газруудад хийгдэх ажлуудыг боловсронгуй болгох саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээг авах</p> <p>1.4. Зоогийн газруудад эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт, ариутгалыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах</p> <p>1.5. Удирдлагыг мэргэжлийн зөвөлгөө, зөвлөмж, танилцуулга, мэдээлэл, судалгаагаар хангах</p> <p>1.6. Бэлэн, бэлэн бус бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага, боловсруулалтын үйл ажиллагаанд хяналт тавих</p>	Эрүүл ахуйд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангасан байна.	Г
	2.1. Хүнсний эрүүл ахуйн чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, боловсронгуй		

2 дугаар зорилтын хүрээнд	<p>болгох санал өгөх</p> <p>2.2. Зоогийн газрын хүнсэнд хэрэглэгдэх махнаас мэдрэхүйн шинжилгээг авч байх</p> <p>2.3. Хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг баримтад тогтмол хяналт тавих</p> <p>2.4. Өдөр тутамд гарч байгаа хоолны дээжид хяналт тавих</p>	<p>Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тогтмол хийж ажилласан байна.</p>	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1. Хариуцсан ажлын хүрээнд зоогийн газруудад хяналт, шалгалт хийх</p> <p>3.2. Эрсдэлийг тодорхойлох зорилгоор тандалт судалгаа хийж, удирлагыг мэдээллээр хангах</p> <p>3.3. Мэдээ тайлан гаргахдаа бодит тоон үзүүлэлтийг хүрэх үр дүнтэй уялдуулан гаргаж байх</p> <p>3.4. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж газрын удирдлагад танилцуулж, тодорхой арга хэмжээг авч ажиллах.</p>	<p>Хяналт шалгалтыг бодит тоо баримт, судалгаанд үндэслэж хийсэн байна.</p>	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1. Өөрийн мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх тал дээр анхаарч, зоогийн газрын ажилтнуудад эрүүл ахуйн заавар, зөвөлгөөг өгч ажиллах</p> <p>4.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах</p> <p>4.3. Мэргэжлийн гарын авлага, зөвлөмж, мэдээллийг судлах, үйл ажиллагаанд ашиглах</p>	<p>Өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, алдаа дутагдал гаргахгүй ажилласан байна.</p>	Г
5 дугаар зорилтын хүрээнд	<p>5.1. Мэргэжлийн чиг үүргийн дагуу холбогдох хууль дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Хууль, тогтоол, дүрэм журмыг хэрэгжүүлж ажилласан байна.</p>	Г
6 дугаар зорилтын хүрээнд	<p>6.1. Албан хэрэг хөтлөлтийн улсын стандартыг дагаж мөрдөн ажиллах</p> <p>6.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах</p> <p>6.3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Албан хэрэг хөтлөлт холбогдох заавар, журмын дагуу хийгдсэн байна.</p>	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Эрүүл ахуйч эмч
Мэргэшил	Хүнсний эрүүл ахуйч чиглэлээр олгох мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	Хоол хүнсний талаар онолын болон практик мэдлэгтэй, хүнс үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн үндсэн мэдлэг, хүнс үйлдвэрлэлийн технологи ажиллагааг удирдах, хянах, шинжилгээ дүгнэлт хийх, туршилт явуулах ур чадвартай байх.
Тусгай шаардлага	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Газрын дарга Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны дарга Зоогийн газрын ахлах менежер Захиргаа, төлөвлөлтийн ерөнхий менежер	
Албан тушаалын шууд харъяалан удирдах албан тушаал:	
Албан тушаалын байгууллага дотор харилцах субъект: Газрын дарга Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны дарга Зоогийн газрын ахлах менежер Ерөнхий тогооч Зоогийн газрын ажилтнууд	Бусад харилцах субъект: Нийслэлийн Засаг захиргааны байранд үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллагын ажилтан албан хаагчид
V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч: Албан тушаалын нэр: ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  (гарын үсэг)	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: Албан тушаалын нэр: НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  (гарын үсэг, тамга)
Б.ЗОЛБАЯР (овог, нэр)	Л.ДЭЛГЭР (овог, нэр)
2023 оны 09 дугаар сарын 15-ны өдөр	2023 оны 09 дугаар сарын 15-ны өдөр